

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Зүүнговь сумын Ерөнхий боловсролын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/074/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Нямбуу

Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.АНХБАЯР ТАНАА

2026.02.24 № УВА-2026/074/НД-СТД-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Зүүнговь сумын сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>546,307,868.47</u></b>	<b><u>474,732,299.36</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	404,780,883.04	333,273,457.98
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	404,780,883.04	333,273,457.98
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	404,780,883.04	333,273,457.98
31211	Төрийн сангийн харилцах	404,780,883.04	333,273,457.98
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	129,234,537.53	129,166,393.48
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	129,234,537.53	129,166,393.48
35430	Сэлбэг хэрэгсэл	2,030,000.00	00.00
35460	Хүнсний материал	15,921,153.00	16,018,111.25
35470	Бусад хангамжийн материал	111,283,384.53	113,148,282.23
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,355,265,565.67</u></b>	<b><u>2,406,045,595.72</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,355,265,565.67	2,406,045,595.72
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,305,947,565.67	2,356,727,595.72
39201	Барилга байгууламж	2,414,069,450.18	2,414,069,450.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-338,707,781.97	-396,972,732.40
39203	Авто тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,000,000.00	-35,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	373,370,330.69	520,131,919.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	-225,352,335.81	-281,478,644.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,425,660.71	102,160,160.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	-83,377,240.13	-85,896,134.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,400,000.00	24,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-813,333.34	-5,693,333.38
39217	Ном	56,932,815.34	66,006,909.94
393	Биет бус хөрөнгө	49,318,000.00	49,318,000.00
39301	Программ хангамж	660,000.00	660,000.00
39302	Хасагдуулга	-660,000.00	-660,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,318,000.00	49,318,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,901,573,434.14</u></b>	<b><u>2,880,777,895.08</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,633,341.52</u></b>	<b><u>60,339,336.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,633,341.52	60,339,336.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,633,341.52	60,339,336.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,753,733.53	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,879,607.99	60,339,336.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,802,000.00	60,339,336.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	77,607.99	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,897,940,092.62</u></b>	<b><u>2,820,438,559.08</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,897,940,092.62	2,820,438,559.08
	Засгийн газрын оруулсан капитал/ЗГСан/ орон нутгийн	1,282,600,835.50	1,282,600,835.50
<b>51101</b>	<b>Өмч-Төрийн өмч</b>	1,282,600,835.50	1,282,600,835.50

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	946,584,985.65	869,083,452.11
<b>51210</b>	<b>Өмнөх үеийн үр дүн</b>	946,584,985.65	946,584,985.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-77,501,533.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	668,754,271.47	668,754,271.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,901,573,434.14</b>	<b>2,880,777,895.08</b>

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,532,595,062.90</b>	<b>2,890,378,701.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>78,630,962.90</b>	<b>176,674,201.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	78,630,962.90	176,674,201.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,630,962.90	176,571,201.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,167,800.00	4,728,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	74,463,162.90	171,843,101.60
120009	Бусад орлого	00.00	103,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300,221,700.00</b>	<b>2,713,704,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	2,467,284,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,467,284,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,153,742,400.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	300,221,700.00	246,420,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,221,700.00	246,420,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,458,605,680.74</b>	<b>2,967,880,235.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,458,605,680.74</b>	<b>2,967,880,235.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,355,136,922.80	2,873,892,685.14
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,515,528,441.45	1,845,681,190.09
210101	Үндсэн цалин	969,482,365.40	1,108,599,136.09
210102	Нэмэгдэл	450,231,396.05	599,782,743.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	37,366,032.00
210104	Урамшуулал	95,814,680.00	99,933,279.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	188,992,407.16	232,065,981.95
210201	Тэтгэврийн даатгал	129,923,852.37	158,232,544.31
210202	Тэтгэмжийн даатгал	15,297,104.46	18,580,359.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,902,660.18	9,725,078.13
210204	Ажилгүйдлийн даатгал	7,173,758.74	9,091,500.02
210205	Эрүүл мэндийн даатгал	28,695,031.41	36,436,500.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	296,405,577.06	362,810,754.00
210301	Гэрэл, цахилгаан	29,284,137.06	32,884,769.32

210302	Түлш, халаалт	267,121,440.00	329,925,984.68
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,952,215.00</b>	<b>5,897,550.00</b>
210402	Тээвэр, шатахуун	00.00	5,897,550.00
210408	Бараа материал акталсны зардал	4,952,215.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>132,752,175.00</b>	<b>227,861,791.75</b>
210502	Хоол, хүнс	132,752,175.00	227,861,791.75
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>1,536,300.00</b>
210604	Урсгал засвар	00.00	1,536,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,152,000.00</b>	<b>2,760,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,152,000.00	2,760,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,199,000.00</b>	<b>20,829,722.02</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,199,000.00	20,829,722.02
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>207,155,107.13</b>	<b>174,449,395.33</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,093,888.05	41,563,749.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	11,095,492.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,061,219.08	121,790,153.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>103,468,757.94</b>	<b>93,987,550.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>101,337,635.00</b>	<b>93,987,550.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,867,535.00	85,431,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,470,100.00	8,555,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,131,122.94</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,131,122.94	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>73,989,382.16</u></b>	<b><u>-77,501,533.54</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>590,652.67</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	590,652.67	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-590,652.67</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>73,398,729.49</u></b>	<b><u>-77,501,533.54</u></b>

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,458,131,900.00</b>	<b>2,718,535,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,167,800.00</b>	<b>4,831,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,167,800.00	4,831,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,167,800.00	4,728,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,167,800.00	4,728,100.00
120009	Бусад орлого	00.00	103,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,453,964,100.00</b>	<b>2,713,704,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	2,467,284,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,467,284,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,153,742,400.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	300,221,700.00	246,420,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,221,700.00	246,420,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,319,419,475.14</b>	<b>2,724,564,225.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,319,419,475.14</b>	<b>2,724,564,225.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,221,449,632.20</b>	<b>2,630,576,675.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,516,616,968.15	1,827,633,405.57
210101	Үндсэн цалин	946,522,457.94	1,103,708,955.57
210102	Нэмэгдэл	455,256,580.21	569,284,787.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	56,490,407.00
210104	Урамшуулал	114,837,930.00	98,149,256.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	186,072,538.94	251,867,500.00
210201	Тэтгэврийн даатгал	122,246,166.41	171,269,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,146,575.18	20,149,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,201,591.66	10,074,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,911,451.38	10,074,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,566,754.31	40,298,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	297,695,577.06	244,883,700.00
210301	Гэрэл, цахилгаан	29,284,137.06	32,884,769.32
210302	Түлш, халаалт	268,411,440.00	211,998,930.68
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	135,467,865.00	222,736,750.00
210502	Хоол, хүнс	135,467,865.00	222,736,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	395,000.00	1,536,300.00

/төгрөгөөр/

210604	Урсгал засвар	395,000.00	1,536,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,184,254.05</b>	<b>25,463,727.49</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,132,800.00	4,728,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,051,454.05	20,735,627.49
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,017,429.00</b>	<b>56,455,292.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,895,843.00	45,359,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,121,586.00	11,095,492.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,969,842.94</b>	<b>93,987,550.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>95,838,720.00</b>	<b>93,987,550.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	63,368,620.00	85,431,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,470,100.00	8,555,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,131,122.94</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,131,122.94	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>138,712,424.86</u></b>	<b><u>-6,028,625.06</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>31,134,800.00</b>	<b>65,478,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>31,134,800.00</b>	<b>65,478,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>31,134,800.00</b>	<b>65,478,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,134,800.00	65,478,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-31,134,800.00</u></b>	<b><u>-65,478,800.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>107,577,624.86</b>	<b>-71,507,425.06</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>297,203,258.18</b>	<b>404,780,883.04</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>404,780,883.04</b>	<b>333,273,457.98</b>

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,282,600,835.50	649,604,245.06	1,443,285,020.67	00.00	3,375,490,101.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,282,600,835.50</b>	<b>649,604,245.06</b>	<b>1,443,285,020.67</b>	<b>00.00</b>	3,375,490,101.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	98,619,933.68	00.00	98,619,933.68
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,282,600,835.50</b>	<b>668,754,271.47</b>	<b>946,584,985.65</b>	<b>00.00</b>	2,897,940,092.62
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,282,600,835.50</b>	<b>668,754,271.47</b>	<b>946,584,985.65</b>	<b>00.00</b>	2,897,940,092.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,282,600,835.50</b>	<b>668,754,271.47</b>	<b>946,584,985.65</b>	<b>00.00</b>	2,897,940,092.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-77,501,533.54	00.00	-77,501,533.54
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,282,600,835.50</b>	<b>668,754,271.47</b>	<b>869,083,452.11</b>	<b>00.00</b>	2,820,438,559.08

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,865,620,600.00	2,543,623,025.06	321,997,574.94
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,865,620,600.00	2,543,623,025.06	321,997,574.94
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,771,504,200.00	2,449,635,475.06	321,868,724.94
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,108,371,700.00	1,827,633,405.57	280,738,294.43
210101	Үндсэн цалин	1,279,899,700.00	1,103,708,955.57	176,190,744.43
210102	Нэмэгдэл	754,665,200.00	569,284,787.00	185,380,413.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	56,490,407.00	-56,490,407.00
210104	Урамшуулал	73,806,800.00	98,149,256.00	-24,342,456.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	263,546,500.00	251,867,500.00	11,679,000.00
210201	Тэтгэврийн даатгал	179,211,400.00	171,269,800.00	7,941,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,083,900.00	20,264,500.00	819,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,542,000.00	8,952,600.00	1,589,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	10,542,000.00	11,082,000.00	-540,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,167,200.00	40,298,600.00	1,868,600.00
2105	<b>Нормативт зардал</b>	222,791,000.00	222,736,750.00	54,250.00
210502	Хоол, хүнс	222,791,000.00	222,736,750.00	54,250.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	35,409,600.00	25,463,727.49	9,945,872.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,027,900.00	4,728,100.00	299,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,381,700.00	20,735,627.49	9,646,072.51
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	141,385,400.00	121,934,092.00	19,451,308.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,223,000.00	110,838,600.00	19,384,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,162,400.00	11,095,492.00	66,908.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	941,164,000.00	939,875,550.00	128,850.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	94,116,400.00	93,987,550.00	128,850.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,560,600.00	85,431,750.00	128,850.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,952,861,200.00	2,472,012,600.00	480,848,600.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,952,861,200.00	2,467,284,500.00	485,576,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,952,861,200.00	2,467,284,500.00	485,576,700.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	4,728,100.00	-4,728,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,728,100.00	-4,728,100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	404,780,883.04	-404,780,883.04
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	333,273,457.98	-333,273,457.98

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>259,620,000.00</b>	<b>246,420,000.00</b>	<b>13,200,400.00</b>	<b>94.9%</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,620,000.00	246,420,000.00	13,200,400.00	94.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,620,000.00	246,420,000.00	13,200,400.00	94.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	257,968,400.00	244,883,700.00	13,084,700.00	94.9%
210301	Гэрэл, цахилгаан	45,852,500.00	32,884,769.32	12,967,730.68	71.7%
210302	Түлш, халаалт	211,046,700.00	211,998,930.68	(952,230.68)	100.5%
210303	Цэвэр, бохир ус	1,069,200.00		1,069,200.00	0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,652,000.00	1,536,300.00	115,700.00	93%
210604	Урсгал засвар	1,652,000.00	1,536,300.00	115,700.00	93%
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>259,620,000.00</b>	<b>246,420,000.00</b>	<b>13,200,400.00</b>	<b>94.9%</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>259,620,000.00</b>	<b>246,420,000.00</b>	<b>13,200,400.00</b>	<b>94.9%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	259,620,000.00	246,420,000.00	13,200,400.00	94.9%
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган ажиллаж, 2025-2026 оны хичээлийн жилд “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, сурагчдыг бие даан сурах арга барилд сургаж, чадваржуулахад хамтын ажиллагааг чиглүүлнэ” зорилгын дор 13 зорилт дэвшүүлэн сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,795.5 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	404,780.9	333,273.5	-71,507.4
Авлага	12,292.4	12,292.4	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	129,234.5	129,166.4	-68.1
Үндсэн хөрөнгө	2,355,265.6	2,406,045.6	50,780.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,901,573.4</b>	<b>2,880,777.9</b>	<b>-20,795.5</b>
Өр төлбөр	3,633.4	60,339.3	56,706.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,897,940.1	2,820,438.6	-77,501.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,901,573.4</b>	<b>2,880,777.9</b>	<b>-20,795.5</b>

Дээрх хүснэгтээс харахад Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь 2024 онд 404,780.9 мянган төгрөг байсан бол 2025 онд 333,273.5 мянган төгрөг болж буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 129,166.4 мянган төгрөг болж 68.1 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш, шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,406,045.6 мянган төгрөг болж 50,780.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 65,478.8 мянга, тайлант онд 121,790.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 60,339.3 мянган төгрөг болж 56,706.0 мянган төгрөгөөр өссөн нь түлш халаалтын өр төлбөр үүсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,820,438.6 мянган төгрөг болж 77,501.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,587,139.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 259,620.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 5,560.8 мянган төгрөгөөр өсгөж, улсын төсвөөс 2,525,886.0 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 426,975.2 мянга, орон нутгийн төсвөөс 259,620.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,952,861.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 259,620.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 399,249.7 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,467,284.5 мянга, орон нутгийн төсвөөс 246,420.0 мянга, үйл ажиллагааны орлого 4,728.1 мянга, нийт 2,472,012.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,543,623.0 мянган төгрөг буюу 88.8 хувьтай байна. Улсын төсвийн дансны мөнгөн хөрөнгө 333,273.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	4,035.0	4,035.0	-	100%
2	Хүүхэд хамгаалал /80233/	5,401.1	1,542.5	3,858.6	28.5%
3	Сургалт семинар /80312/	2,757.7	2,723.0	34.7	98.0%
4	Эрүүл мэндийг дэмжих /81605/	3,192.5	1,465.9	1,726.6	54.0%
5	Үдийн цай хөтөлбөр	85,560.6	85,431.8	128.9	99.8%
6	Дотуур байрны үйлчилгээ /81806/	597,275.1	520,785.4	76,489.7	87.1%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	44,909.8	44,909.8	-	100.0%
8	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх/81823/	16,275.2	3,820.0	12,455.2	23.0%
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/	58,324.9	54,576.7	3,748.2	93.5%
10	Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагаа /81834/	1,875,910.6	1,662,010.7	213,899.9	88.5%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	90,647.9	74,996.5	15,651.4	82.7%
13	Сурах бичгийн түрээс /81848/	5,027.9	4,728.1	299.8	94.0%
14	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/	11,197.3	9,897.0	1,300.0	88.3%
15	ЗД-ын нөөц хөрөнгөөс хувиарилсан	20,000.0	19,924.5	75.5	99.6%
15	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	103.0		103.0	0.0%
16	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	246,420.8	246,420.0	0.00	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

*/мянган төгрөг/*

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	660.0	Асолюс программ ашиглаж байна.
2	Унаа, хоолны зардал	56,490.4	2025 онд хоолны зардлыг нэг өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож 56,490.4 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар	3,820.0	Үндэсний болон орон нутгийн төрөлжсөн сургалт, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаа багш нарыг чадавхжуулах сургалтын зардал гарсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	-	Увс аймгийн Зүүнговь сумын сургууль нь 2025 онд 65 орон тоо ажиллахаар батлагдсанаас 63 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотуур байр, үдийн хоолны 2 тендер худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд: Хүүхдийн үдийн хоолны материал нийлүүлэх 111,188.0 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоол 255,188.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан шалгарсан компанитай гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж

заасны дагуу Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 2,458,605.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 24,586.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,911,108.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 29,111.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 23,288.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 175, хугацаа хоцроон байршуулсан 8 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж асуудал танилцуулж ярилцлагын тэмдэглэл хөтөлж танилцуулсан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчил илрээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 101,485.2 мянган төгрөгийн 1 алдаа илэрсэнд аудитын явцад 101,485.2 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

#### Залруулсан алдаа:

Зүүнговь сумын ерөнхий боловсролын сургууль нь үр дүнгийн тайланд цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 18,047.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 57,587.7 мянга, эд хогшил, урсгал заварын зардлыг 586.3 мянга, дотоод томилолтын зардлыг 2,760.0 мянган төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 18,903.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 152.0 мянга, нормативт зардлыг 253.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,194.3 мянган төгрөгөөр илүү, илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалт "Бүх зардал" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд	1	101,485.2					1	101,485.2				
Дүн	1	101,485.2					1	101,485.2				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/


АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Б.НЯМБУУ/



2026 оны 02 сарын 24-ний өдөр